

Эгзэгтэй цэгийн аюултай байдлыг шинжлэн хянах  
тогтолцооны баталгаажуулалтын журам

1. Ерөнхий зүйл

Энэхүү баримт бичиг нь эгзэгтэй цэгийн аюултай байдлыг шинжлэн хянах /ЭЦАБШХ/ тогтолцооны MNS CAC 1:2003 «Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим»-д олон улсын стандартаар тогтоосон шалгуурын дагуу ЭЦАБШХ тогтолцоог баталгаажуулах ажиллагааг гүйцэтгэх нийтлэг журмыг тогтооно.

2. Норматив ишлэл

Энэхүү журамд дараахь хууль тогтоомж, стандарт, бусад баримт бичгийг иш татан хэрэглэсэн болно. Иш татсан баримт бичигт хугацаа заасан бол зөвхөн тухайн хэвлэлийг ашиглана. Хэрэв хугацаа заагаагүй бол иш татсан баримт бичиг болон түүнд нэмэлт оруулсан өөрчлөлтийн хамгийн сүүлчийн хэвлэлийг ашиглана. Үүнд:

2.9 “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль

2.10 MNS ISO 19011 “Чанарын болон байгаль орчны удирдлагын тогтолцоонд, аудит явуулах заавар”

2.11 MNS CAC1:2003 “Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим”

3. Нэр томъёо, тодорхойлолт

Энэ журамд MNS CAC1:2003, ISO 22000:2007, MNS ISO/IEC17000:2005, MNS ISO 19011:2003 стандартуудад тусгасан нэр томъёо, тодорхойлолтуудаас гадна дараахь тодорхойлолтуудыг мөн хэрэглэнэ. Үүнд:

3.1 ЭЦАБШХ тогтолцооны баталгаажуулалт: Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчмын дагуу хүсэлт гаргасан этгээдийн баримтжуулсан тогтолцоог эрх бүхий байгууллагаас тогтоосон норматив шалгуурын дагуу үнэлж дүгнэн, хэрэгжиж байгааг нотлон гэрчилгээ олгох үйл ажиллагаа.

ТАЙЛБАР: Хэрэв Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид тусгайлан өөрөөр заагаагүй бол ЭЦАБШХ тогтолцооны баталгаажуулалт нь зөвхөн сонирхогч талын хүсэлтийн дагуу сайн дурын үндсэн дээр явагдана.

3.2 ЭЦАБШХ тогтолцооны баталгаажуулалтын байгууллага: ЭЦАБШХ тогтолцооны баталгаажуулалтын ажлыг хууль тогтоомжийн дагуу эрхлэн явуулах эрх бүхий байгууллага.

ТАЙЛБАР: ЭЦАБШХ тогтолцооны баталгаажуулалтыг “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол Улсын хуулийн 16 дугаар зүйлийн дагуу Стандартчиллын төв байгууллага, эсхүл түүнээс баталгаажуулалт хийх эрх авсан байгууллага явуулна.

3.3 Аудитаар шалгуулагч: Аудитад орж байгаа байгууллага.

3.4 Магадлах аудит: ЭЦАБШХ тогтолцоо нь холбогдох шаардлагад үргэлжлэн нийцэж буй эсэхийг тодорхойлох зорилгоор гэрчилгээний хүчинтэй хугацаанд тодорхой давтамжтай явуулах аудит.

4. Баталгаажуулалтад оролцогч талуудын эрх, үүрэг

Тогтолцооны баталгаажуулалтын байгууллага нь:

- Тухайн байгууллагатай хийсэн гэрээний дагуу ЭЦАБШХ тогтолцоонд магадлах аудит, давтан аудит хийх;

- Тухайн баталгаажуулалтын ажлын хүрээнд заасан баталгаажуулалт, аудитын ажлыг томилогдсон аудитын баг хариуцан гүйцэтгэх.

Аудитаар шалгуулагч байгууллага нь:

- ЭЦАБШХ тогтолцоог баталгаажуулах хүсэлтээ илэрхийлсэн өргөдлөө 1 дүгээр хавсралтын дагуу баталгаажуулалтын байгууллагад гаргах;
- Баталгаажуулалт, аудитын ажлын талаар санал, гомдлоо холбогдох байгууллагад гаргах.

ЭЦАБШХ тогтолцооны гэрчилгээ эзэмшигч нь баталгаажуулалтын байгууллагатай гэрчилгээ эзэмших тухай гэрээ байгуулан ажиллана.

## 5. ЭЦАБШХ тогтолцооны баталгаажуулалтын баримт бичгүүд

5.1 ЭЦАБШХ тогтолцооны баталгаажуулалтыг явуулахад стандартаар тогтоогдсон техникийн норматив шаардлага, шалгуур үзүүлэлт, бусад баримт бичгийг тус тус ашиглана.

5.2 Баталгаажуулалтын шалгуур баримт бичгүүдэд MNS SAC 1:2003 стандартын шаардлага хамаарна.

5.3 Баталгаажуулалтын журмын баримт бичигт MNS ISO 19011:2003 стандарт, энэхүү журам болон баталгаажуулалтын байгууллагын холбогдох бусад баримт бичгүүд хамаарна.

## 6 ЭЦАБШХ тогтолцооны баталгаажуулалт явуулах үе шатууд

ЭЦАБШХ тогтолцооны баталгаажуулалтын ажил нь дараахь үйл явцуудаас бүрдэнэ. Үүнд:

- ЭЦАБШХ тогтолцоонд баталгаажуулалт хийлгэх тухай өргөдөл хүлээн авах;
- баримт бичигт дүн шинжилгээ хийх;
- аудитын багийг томилох;
- аудит явуулах;
- аудитын үр дүнд илэрсэн үл тохирлыг залруулах;
- аудитын тайлан бэлтгэж баталгаажуулалтын зөвлөлд танилцуулах
- гэрчилгээ олгох;
- магадлах аудит;
- давтан аудит;
- баталгаажуулалтын үр дүнг мэдээлэх

### 6.2 Баталгаажуулалт хийлгэх тухай өргөдөл хүлээн авах

6.1.1 ЭЦАБШХ тогтолцоондоо баталгаажуулалт хийлгэх хүсэлт гаргасан байгууллага нь энэ тухай өргөдлөө 1 дүгээр хавсралтын дагуу гаргаж баталгаажуулалтын байгууллагад ирүүлнэ.

6.1.2 Өргөдөл гаргагч нь ЭЦАБШХ тогтолцоог баталгаажуулах байгууллага болон энэхүү журмын талаарх мэдээллийг төв, орон нутгийн стандартчилал, хэмжилзүйн байгууллагаас авч болно.

6.1.3 Өргөдөл гаргагч нь баталгаажуулах журамд заасан шаардлагатай техникийн баримт бичгийг өргөдөлд хавсаргасан байна.

### 6.2 Баримт бичигт дүн шинжилгээ хийх

6.2.1 Баталгаажуулалтын байгууллага нь өргөдөл болон холбогдох материал, баримт бичигт 2 дугаар хавсралтын дагуу дүн шинжилгээ хийнэ. Шаардлагатай гэж үзвэл нэмэлт баримт бичгийг шаардаж, дүн шинжилгээнд хамруулна.

6.2.2 Дүн шинжилгээний дүнд баримт бичгийн бүрдэлт хангалттай гэж үзвэл дараагийн үе шатанд орно. Харин хангалтгүй байвал энэ тухай өргөдөл гаргагчид албан ёсоор мэдэгдэнэ.

### 6.3 Аудитын багийг томилох

6.3.1 Баталгаажуулалтын байгууллага нь баримт бичигт дүн шинжилгээ хийсний дараа аудитын багийн бүрэлдэхүүнийг томилж, тухайн аудитын зорилт, хамрах хүрээ, шалгуурыг тодорхойлно. Үүнд MNS ISO 19011:2003 стандартын 6.2-р заалтыг удирдлага болгоно

### 6.4 Аудит явуулах

6.4.1 Газар дээр нь аудит явуулахын өмнө аудитын төлөвлөгөөг 3 дугаар хавсралтын дагуу боловсруулах, аудитын багийн гишүүдийн ажил, үүргийг хуваарилах, аудитын ажлын баримт бичгүүдийг боловсруулах зэрэг ажлуудыг хийнэ. MNS ISO 19011:2003 стандартын 6.4-р заалтыг баримтална.

6.4.2 Аудитыг явуулахдаа MNS ISO 19011:2003 стандартын 6.5-р заалтыг баримтална.

### 6.5 Аудитын тайлан бэлтгэж баталгаажуулалтын зөвлөлд танилцуулах

6.5.1 Аудитын баг нь аудитын тайланг 4 дүгээр хавсралтын дагуу бүрдүүлнэ. Үүнд: MNS ISO 19011:2003 стандартын 6.6-р заалтыг баримтална.

6.5.2 Хэрэв аудитын үр дүнд залруулах шаардлагатай үл тохирол илрээгүй бол аудитын баг нь аудитаар шалгуулагчид гэрчилгээ олгуулах саналыг баталгаажуулалтын зөвлөлд танилцуулж шийдвэр гаргуулна.

6.5.3 Баталгаажуулалтын байгууллага нь аудитын тайлангийн нууцыг чанд хадгалах бөгөөд хэрэв шаардлага гарвал аудитаар шалгуулагчид мэдэгдэнэ.

### 6.6 Аудитын үр дүнд илэрсэн үл тохирлыг залруулах

Хэрэв аудитын явцад залруулах шаардлагатай үл тохирол илэрсэн бол 5 дугаар хавсралтын дагуу бүртгэж, аудитаар шалгуулагч нь тайланд заасан хугацааны дотор залруулах арга хэмжээг авч гарсан үр дүнгийн талаар баталгаажуулалтын байгууллагад албан ёсоор ирүүлнэ.

Үүнийг аудитын баг магадлан тогтоосны дараа холбогдох саналаа бэлтгэж шийдвэрлүүлнэ.

### 6.7 Гэрчилгээ олгох, тэмдэглэгээ хэрэглэх

6.7.1 Баталгаажуулалтын байгууллага нь 6.5.4-т заасныг үндэслэн өргөдөл гаргагчид ЭЦАБШХ тогтолцоо нэвтрүүлсэн тухай гэрчилгээ олгож, тэмдэглэгээг хэрэглэх тухай гэрээ байгуулан ажиллана.

6.7.2 ЭЦАБШХ тогтолцооны гэрээнд гэрчилгээ эзэмшигч ба баталгаажуулалтын байгууллагын эрх, үүрэг, гэрчилгээний хугацаа, ЭЦАБШХ тогтолцооны хамрах хүрээ, гэрчилгээ эзэмших эрхийг түр зогсоох, хүчингүй болгох, давтан аудит явуулах нөхцлүүдийг тусгана.

6.7.3 Баталгаажуулалтын байгууллага нь магадлах аудитын хөтөлбөрийг MNS ISO 19011:2003 стандартын 5-р бүлгийн шаардлагын дагуу боловсруулан хэрэгжүүлнэ.

### 6.8 Магадлах аудит

6.8.1 Үйлдвэрлэлийн үйл явцаас хамааран бүтээгдэхүүний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй нөлөөллийн зэрэг, үйлдвэрлэлийн тогтвортой байдал, үйлдвэрлэлийн хэмжээ, чанарын удирдлагын тогтолцоотой эсэх, магадлах аудитын өртөг зэргийг шалгуур болгож магадлах аудитын давтамж ба хамрах хүрээг тогтооно.

6.8.2 Магадлах аудитыг энэхүү журмын 6.1-6.4, 6.6, 6.7 дугаар бүлэгт заасны дагуу явуулна.

6.8.3 Магадлах аудитын багийн ахлагч нь анхны аудитын багт орж ажилласан аудитор байж болохгүй.

6.8.4 Магадлах аудитын үр дүнгийн дагуу баталгаажуулалтын байгууллага нь дараах тохиолдолд гэрчилгээг түдгэлзүүлэх эсвэл хүчингүй болгож болно. Үүнд:

- норматив бичиг баримтын шаардлагад нийцэхгүй байх;
- эгзэгтэй цэгийн хяналтын тогтолцоонд тавих шаардлага өөрчлөгдсөн (эсвэл биелдэггүй) бөгөөд энэ нь бүтээгдэхүүний аюулгүй байдлын шаардлагад үл тохирох байдалд хүргэхээр байх.

6.8.5 Аудитаар шалгуулагч нь баталгаажуулалтын байгууллагатай зөвшилцөж тогтоосон залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх замаар илэрсэн үл тохирлыг арилгаж стандартын шаардлагад тохирсныг батлаж чадах тохиолдолд дахин аудит хийх хүртэл тохирлын гэрчилгээг түдгэлзүүлэх шийдвэрийг гаргана. Үүнийг хэрэгжүүлэх боломжгүй бол гэрчилгээг хүчингүй болгоно.

Гэрчилгээг түдгэлзүүлсэн, эсвэл хүчингүй болгосон тухай мэдээллийг түүнийг олгосон байгууллага өргөдөл гаргагч, хэрэглэгчид, Стандартчиллын төв байгууллага болон бусад сонирхогч талуудад хүргэнэ.

### 6.9 Давтан аудит явуулах

Давтан аудитыг дараах 2 тохиолдолд явуулна. Үүнд:

6.9.1 Гэрчилгээ эзэмшигчийн гэрээний хугацаа дууссан;

6.9.2 Хэрэв гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ, өмч эзэмшигч, техник, технологи өөрчлөгдөх, эсвэл гэрчилгээ эзэмшигчийн ЭЦАБШХ тогтолцоо нь тогтоосон шаардлагад цаашид нийцэхгүй байгаа нь тогтоогдсон;

6.9.3 Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацаа дуусахаас 3 сарын өмнө давтан аудит хийлгэх тухай өргөдлөө энэ журмын 6.1.1-ийн дагуу гаргана.

6.9.4 Давтан аудитыг энэ журмын 6.1-6.7 дугаар бүлэгт заасны дагуу явуулна.

6.9.5 Давтан аудитын дүнг үндэслэн гэрчилгээ эзэмших болон гэрээний хугацааг сунгах асуудлыг шийдвэрлэнэ.

### 3.10 Үл тохирол илэрсэн тохиолдолд авах арга хэмжээ

3.10.1 Үл тохирол илэрсэн тохиолдолд дараах арга хэмжээг авна. Үүнд:

- гэрчилгээг түдгэлзүүлэх;
- залруулах арга хэмжээг биелүүлэх хугацааг тогтоох;
- үйлдвэрлэгч (худалдагч)-аас залруулах арга хэмжээг биелүүлж буй байдалд хяналт тавих.

3.10.2 Энэ үед үйлдвэрлэгч (худалдагч)-ээс дараах үйл ажиллагааг явуулна:

- илэрсэн зөрчлийн хамрах хүрээг тодорхойлох;
- хэрэглэгчдэд болон олон нийт, сонирхогч байгууллагуудад тухайн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг ашиглах (хэрэглэх) нь аюултай болох талаар мэдэгдэх.

3.10.3 Илэрсэн үл тохирлыг бүрэн залруулсны дараа баталгаажуулалтын байгууллага дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:

- залруулах арга хэмжээний өмнө ба дараах үеийн үйлдвэрлэлээс гарсан бүтээгдэхүүнийг ялгах, шинэ тэмдэглэгээг үйлдвэрлэгч /худалдагч/-ээр тавиулах;
- сонирхогч талуудад мэдээлэх.

3.10.4 Үйлдвэрлэгч (худалдагч)-ийн зүгээс залруулах арга хэмжээг биелүүлээгүй буюу энэ нь үр нөлөөгүй болсон үед баталгаажуулалтын байгууллага нь гэрчилгээг хүчингүй болгох.

3.11 Баталгаажуулалтын байгууллага нь өргөдөл гаргагчид, түүний хүсэлтээр баталгаажуулах ажиллагааг явуулсантай холбогдолтой мэдээллийг өөрийн эрх мэдлийн хүрээнд өгнө.

оооОооо